## "ДАРХАН-Х БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИА .ГЧИЙН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

2022.06.10 — Дархан-Уул аймаг

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт | Гүйц/ хувь | ХШҮДА хариуцсан ажилтны үнэлгээ | Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн Даргын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Стратеги төлөвлөгөөний зорилго №1** Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах. | | | | | |
| | Зорилт №1<br><br>Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэлийг барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан | 1.1 Барилга угсралт, засвар шинэчлэлтийн 46 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах. | Барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 35,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлж ажилласан ба 48 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95%-иас дээш хангуулан 19 лабораторийн сорил шинжилгээ хийлгэж ажлыг явцыг 400 фото зургаар баримтжуулж үе шатны 33 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулсан. Гүйцэтгэгч байгууллагуудын гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж 8 санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан.<br>Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн-10 төсөл, арга хэмжээ | 100% | 95% | |
| | | 1.2 Инженерийн шугам сүлжээ-/Цэвэр ус, дулаан хангамж, бохир ус татан зайлуулах/-Нийт 10 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах. | 2022 оны эхний хагас жилийн байдлаар инженерийн шугам сүлжээ /Цэвэр ус, дулаан хангамж, бохир ус татан зайлуулах/-ний 14.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээ, хамтарсан техник хяналтын 4 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба 12 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95%-иас дээш хангуулан 9 лабораторийн сорил шинжилгээ, тохирлын гэрчилгээ хийлгэн, ажлын явцыг 80 фото зургаар баримтжуулан, ил далд ажлын 21 актыг баталгаажуулж гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж 3 гүйцэтгэлийг баталгаажуулсан.<br>**Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн-1 төсөл, арга хэмжээ.** | 100% | 91% | |
| | | 1.3 Авто зам, замын байгууламжийн нийт 24 төсөл арга хэмжээнд захиалагчийн | Авто зам, замын байгууламжийн 53.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг | 100% | 98% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулах | өдөр тут н болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах | хэрэгжүүлж ажилл ба 67 удаа зөвлөмж, үүрэг даалгаврыг өгсөн ба биелэлтийг 97%-иас дээш хангуулан 4671 цэгт түвшин шалгаж, 300 цэгт нягт шалгаж, төсөл, арга хэмжээний ажлын явцыг 2328 фото зургаар баримтжуулсан.<br>Үе шатны ажил эхлүүлэх 572ш рекуст, далд ажлын 286 актыг баталгуужуулсан.<br>14 объектийн гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн замын ажлын тоо хэмжээг тулган шалгаж гүйцэтгэлийг баталгаажуулсан.<br>**Байнгын ашиглалтад оруулсан 7 төсөл, арга хэмжээ** | | | |
| | | 1.4 Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн нийт 12 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах | Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн 5.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ, хамтарсан техник хяналтын 10 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж 43 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг 95% иас дээш хангуулан 3 лабораторийн сорил шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториар шинжүүлсэн. Ажлын явцыг фото зургаар баримтжуулан үе шатны ажлуудад хэмжилт шалгалт хийж 7ш актыг баталгаажуулсан. Гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж 3 гүйцэтгэлийг баталгаажуулсан.<br>Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн-2 төсөл арга хэмжээ | 100% | 90% | |
| | | 1.5 Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах **Мон 3244/3245** төслийн ажил | Пфайфер-ЭМИТ түншлэлийн гүйцэтгэж байгаа Мон 3244/3245 төсөл нь түр хугацаагаар зогссон. Нийт төслийн ажлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 77% тай байна. | | | |
| | | 1.6 Гүйцэтгэлийн төсөв хянан баталгаажуулах | 2022 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 56.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 53 төсөл, арга хэмжээ буюу нийт 108.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 4,431.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулсан.<br>Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах магадлашгүй ажил болон бусад хийгдээгүй ажлын зардлаас 0,8 сая төгрөгийг хэмнэлт үүсгэж ажилласан | 100% | 100% | |
| | | | **Хэсгийн дүн** | **100%** | **94,8%** | |
| | | | | | | |
| 2 | 2.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, газрын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион | 2.1.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах | Батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн 8 гэрээгээр 4 инженер ажилд аван нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. Бүтээн байгуулалтын ажилд багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай мэргэшсэн инженерүүдийг томилон | 100% | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх | | ажиллуулж байна. | | | |
| | | 2.1.2 Сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах. | 2022 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ИТА, албан хаагчид нь мэдлэг мэргэшлээ дээшлүүлэн суралцаж байгаа ба барилгын инженер Т.Эрдэнэбаатар нь Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Мэргэшсэн инженерийн зэрэг горилох" 10 багц цагийн сургалт, Авто замын инженер Д.Аюурзана нь "Авто замчдын холбоо"-ноос зохион байгуулсан "Хяналтын инженер" ийн сургалтад хамрагдаж сертификатаа авсан. Мөн мэргэшсэн инженерийн зэрэг горилох сургалт, INDOR CAD программын мэргэшүүлэх сургалт, Авто зам, гүүрийн инженерүүдийг "Геодезийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт"-уудад тус тус хамрагдсан. Цахилгааны инженер Х.Идэр нь "Зөвлөх инженер"-ийн шалгалт өгч эрхээ авч Монгол улсын зөвлөх инженерийн болзол хангасан.<br>Авто замын инженер Д.Эрдэнэ нь "Автокад программтай ажиллах" талаарх сургалтад хамрагдсан.<br>Мөн байгууллагын дотоод сургалтуудыг 12 удаа ИТА, албан хаагчид нь ээлжлэн зохион байгууллаа.<br>Үүнд:<br>• Төсөв хэрхэн хянах вэ?<br>• Захиалагчийн техникийн хяналтын үүрэг роль<br>• Фидикийн гэрээний тухай ойлголт<br>• Байгууллагын дотоод журам<br>• "Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах болон ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг дахин төлөвлөн барилгажуулах<br>• Барилгын зураг төсөл, угсралт, материал технологийн талаарх сургалт<br>• Багаж тоног төхөөрөмжүүдтэй хэрхэн ажиллах.<br>• Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулдаг сар бүрийн сургалтууд.<br>Мөн Авилгатай тэмцэх газраас Дархан-Уул аймагт 2022 онд зохион байгуулсан "Авилгын нийгмийн хор аюулыг танин мэдэх ба авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшлийн талаар сургалт", Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан "Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөгөөн", "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 3 хэсэгт чуулган", Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан "Барилга угсралтын ажилд гарч байгаа алдаа дутагдал , барилгын зураг төсөлд гарч буй алдаа дутагдал хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй удирдлага зохион байгуулалтын чиглэлээр" сургалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион | 100% | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан "Эд хер[illegible]н улсын үзлэг тооллогод хэрхэн хамрагдах" талаарх сургалт зөвлөмжид байгууллагын удирдлагууд, ИТА, албан хаагчид хамрагдаж мэдлэг, мэргэшлээ дээшлүүллээ.<br>Дархан-Уул аймгийн "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн-2022"-т байгууллагын удирдлага, ИТА нар оролцлоо. | | | |
| | 2.2 Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх | 2.2.1 Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх | 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 78 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэн ажилласан ба аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хуралд долоо хоног бүрийн мягмар гаригт буюу нийт 16 удаа оролцон барилгын ажлын явцын талаар мэдээ тайланг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргуулж байв. Мон 3244/3245 төслийн үйл ажиллагаа нь 2022 он гараад зогссон тул мэдээ тайлан аваагүй.<br>Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан ба худалдан авах ажлын төлөвлөгөө, тайланг аймгийн ОНӨГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 2021 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид 2022 оны 05 дугаар сард танилцуулсан.<br>Санхүүгийн ил тод байдлын мэдээг shilendans.gov.mn сайтад сар бүр гаргаж олон нийтэд мэдээлсэн. Мөн 2021 оны жилийн эцс ийн санхүүгийн тайланг гарган ЦЭСБ аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн.<br>2021 оны жилийн эцсийн архивын хадгаламжийн нэгжийн мэдээг аймгийн Архивын тасагт хугацаанд нь хүргүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын захирамжийн үүрэг даалгаврын хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хугацаанд нь хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 9-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод хамрагдаж мэдээ тайланг цахимаар болон цаасаар аймгийн ОНӨГ-т хүргүүллээ | 100% | 100% | |
| | | 2.2.1 Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах | Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээллийг Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т долоо хоног бүр буюу 2022 оны эхний хагас жилд 16 удаа тайлагнасан.<br>Барилга угсралт, засвар шинэчлэлт өргөтгөлийн 78 төсөл, арга хэмжээ бүрээр объектын тайлан гаргаж газрын мэдээллийн санг бүрдүүлж ажиллаж байгаа ба | 100% | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээ тайланг ай н ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэн ажиллалаа. УИХ-ын гишүүн Г.Дамдинням, Сангийн сайд Б.Жавхлан нар нь Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй танилцах үед бүтээн байгуулалтын ажлын явц, мэдээ тайланг барилга усгралтын талбай дээр очиж танилцуулсан. 2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн аудит орсон ба зөрчил дутагдалтай 4 төслийн зөрчлийг арилгуулж тайланг Аймгийн Аудитын газарт хүргүүлсэн. 2022 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 155 албан бичиг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн. 165 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа. | | | |
| | 2.3 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах. | 2.3.1 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. | Байгууллагын da.barilga.gov.mn вэб хуудас, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар цахим хуудсаар дамжуулан Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа барилга угсралтын ажлын явцын мэдээ, мэдээллийг 142 удаа нийтэлж олон нийтэд хүргүүлэн ажиллалаа. Байгууллагын фэйсбүүк хуудаст байршуулсан барилга угсралтын төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээлэл нь давхардсан тоогоор 29835 хүнд хүрсэн үзүүлэлттэй байгаа ба 1060 хүнд таалагдаж 1098 хүн дагасан байна. | 100% | 100% | |
| | 2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | 2.4.1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Холбогдох хууль тогтоомж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа. Аймгийн засаг Дарга, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулсан нийт 78 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Хууль тогтоомжийг үндэслэл болгон Даргын А тушаал 42 ш, Б тушаал 32 ш гарган мөрдөж ажилласан. Газрын хэмжээнд ажилчдаас ирүүлсэн 10ш өргөдлийг бүртгэн газрын Даргад танилцуулж хугацаанд нь шийдвэрлэсэн.Иргэд, ААН байгууллагаас ирүүлсэн 5 гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэж хариу өгсөн. | 100% | 100% | |
| | 2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах. | 2.5.1 Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан үйл ажиллагаа явуулах. | 2022 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 4,2 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээ, бичиг хэрэг, шатахуун, сэлбэгийн зардалд зарцуулсан 15,6 сая ба цалингийн зардалд 68,3 сая төгрөг, бусад зардалд 1,1 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 89,2 сая төгрөг зарцуулсан. | 100% | 100% | |
| | | 2.5.2 Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад | 2021 оны жилийн эцсийн тайлан ЦЭСБ аудит ХХК-иар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал | 100% | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нийцүүлэ гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх | дүгнэлттэй. Санхү ін тайлан, мэдээг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. | | | |
| | | 2.5.3 Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах. | 2022 онд борлуулалтын орлого нь 96.5 сая төгрөгөөр бүрдүүлсэн ба үйл ажиллагааны зардалд 89.2 сая төгрөгийг зарцуулсан. Нийт 39.4 сая төгрөгийн татвар, ноогдол ашгийн өрийг барагдуулан, аймгийн төсөвт цэвэр ашгийн 25% иар буюу 19,9 сая төгрөгийн ноогдол ашгийг аймагт төвлөрүүлсэн | 100% | 100% | |
| | | 2.5.4 Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Газрын 2022 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөний дагуу бараа материал, шатахууны талон худалдан авч анхан шатны баримтыг үндэслэн орлогод аван шаардах хуудсыг үндэслэн ажилтнуудад олгосон. Монгол улсын Засгийн газрын 9-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эд хөрөнгийн улсын үзлэг тооллого"-д 2021 оны жилийн эцсийн байдлаар хамрагдсан. Тооллогоор дутсан, илүүдсэн хөрөнгө байхгүй. Нийт 69,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон.<br>2022 онд барилга угсралт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор 19,8 сая төгрөгөөр Тоёота приус 41 маркийн суудлын автомашин худалдан авч комисс ажиллуулсан. Мөн 27,2 сая төгрөгөөр дараах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авч комисс ажиллуулсан.<br>• Лазержет принтер-2ш<br>• Делл Кор i5 компьютер-2ш<br>• Чийг хэмжигч багаж-1ш<br>• Колида К5 Жи пи эс төхөөрөмж/ком/-1ш<br>Шатахуун худалдан авах үнийн саналыг 3 байгууллагад хүргүүлж Шунхлай трейдинг ХХК-тай гэрээ байгуулан сар бүр шатахууныг талоноор хүлээн авч "Шатахуун худалдан авч зарцуулан ажиллаж байна. Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас жилээр зохион байгуулсан.<br>Мөн байгууллагын 23-47 ДАА автомашинд тос маслыг хугацаанд нь солиулах үйлчилгээ хийлгэсэн ба Альфа авто засварын газраас сэлбэг хэрэгсэл авч машины бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан. | 100% | 100% | |
| | 2.6 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, | 2.61 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар | Улсын комиссоор ашиглалтад оруулсан барилга байгууламжуудад гарсан зөрчлийг ашиглагч байгууллагуудаас ирсэн гомдол, саналыг үндэслэж гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаат хугацаанд нь засварлуулах ажлыг хяналт гүйцэтгэж байсан инженерүүдээр хариуцуулан гүйцэтгүүлсэн. Жишээ нь Наран сивил ХХК-ийн гүйцэтгэсэн "Ахмадын байрны | 100% | 95% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах. | хангах | өргөтгөлийн ажил", Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 оны гүйцэтгэлийн аудитын шалгалт хийсэн ба аудитаар илэрсэн барилга угсралтын 4ш зөрчил дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. | | | |
| | | 2.6.2 Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх. | 2021 оны газрын үйл ажиллагааны тайлан, 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг холбогдох аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хугацаанд нь хүргүүлсэн ба 2022 оны 05 дугаар сард аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд 2021 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан. Газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Инженер техникийн ажилтан, албан хаагчид нь 2022 онд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлсэн объект тус бүрээр тайланг гарган газрын мэдээллийн санг үүсгэн ажилласан ба эхний хагас жилийн тайланг Аймгийн ЗДТГ ын ХОХБТХ-т хүргүүлсэн. Мөн 2022 оны санхүүгийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байгаа ба 2021 оны санхүүгийн тайланг ЦЭСБ аудит ХХК-иар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. | 100% | 100% | |
| Хэсгийн дүн | | | | 100% | 99,6% | |
| **Нийт дүн** | | | | **100%** | **97,2%** | |

**Санал дүгнэлт, зөвлөмж:**

"ДХББЗГ" ОНӨААТҮГ нь 2022 онд 90 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ба эхний хагас жилийн байдлаар 2021-2022 онд шилжсэн 25 төсөл, арга хэмжээ, шинээр 53 төсөл арга хэмжээнд буюу нийт 108.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

Зорилт №1 стратеги төлөвлөгөөний 6 арга хэмжээ, Зорилт №2 стратеги төлөвлөгөөний 12 арга хэмжээнд буюу удирдлагын үйл ажиллагаа, инженерүүдийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд тус тусад нь үнэлэхэд нийт үнэлгээгээр.............тай буюу ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.

*Цаашид анхаарах асуудлын хувьд:*

1. Төслийн ажил гүйцэтгэх графикийн хугацааг бодитойгоор тооцох.

3. Техникийн тодорхойлолтод заагдсан материал, хийцүүдийг ажил гүйцэтгэх үед тулгаж шалгах.
4. Улсын комисс хүлээн авсны дараа ашиглагч байгууллагаас гомдол, санал ирүүлсэн тохиолдолд төсөл, арга хэмжээний баталгаат хугацааны засварыг цаг алдалгүй хугацаанд нь засварлуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Үнэлгээ хийсэн:
Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн Дарга (П.Батсүх)

Танилцаж зөвшөөрсөн:
Дарга (Д.Батбаяр)

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажилтан:
Ерөнхий инженер (Ч.Батбулган)

30